



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/346

Улаанбаатар хот

Г Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах хашааг хариуцан ажиллах хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15, 15 дугаар зүйлийн 15.4, 15.5 дах заалт, Нийслэлийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх” журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Цэрэн
Дүүргийн менежер

Гишүүд:

Л.Саруултуяа
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Ч.Байгаль
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

М.Цогзолмаа
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Т.Дамбийням
Дүүрэг дэх Цагдаагийн газрын дарга

Д.Бат-Эрдэнэ
Онцгой байдлын хэлтсийн дарга

Б.Сувд-Эрдэнэ
Мал эмнэлгийн тасгийн дарга

Д.Батчимэг
Газар, зохион байгуулалтын албаны дарга

Нарийн бичиг:

Б.Нарантуяа
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

1720010923

3.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Цэрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2024 оны 06 дугаар сарын
06-и. өдрийн 11:16 дугаар
захирамжийн хавсралт

ДҮҮРГИЙН МАЛ АЖ АХҮЙ ЭРХЛЭХИЙГ ХОРИГЛОСОН БҮСЭД
НЭВТЭРСЭН МАЛЫГ ТҮР ХАДГАЛАХ ХАШААГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай” 09 дүгээр тогтоол.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Сонгон шалгаруулалтад оролцогч нь малын эмчтэй Хан-Уул дүүрэгт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байна.

Гурав. Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа

3.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг дүүргийн <https://khanuul.mn/> цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээллэнэ;

3.2. Сонгон шалгаруулалтын хүсэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 08:00 цагаас 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 17:00 цаг хүртэл Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст цаасаар хүлээн авна;

3.3. Сонгон шалгаруулалтад оролцогчдын хүсэлтийг тавигдах шаардлага, бүрдүүлсэн баримт бичгийн бурдлийн дагуу магадлан шалгаж, дүнг нийтэд мэдээллэнэ;

Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага

4.1. Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах хашааг хариуцан ажиллах хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1. Малыг түр хадгалах хашаатай байх;

4.1.2. Малыг өвс, тэжээл, усаар хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

4.1.3. Халдварт өвчний сэжиг бүхий малыг тусгаарлах хэсэгтэй байх;

4.1.4. UCS1902B:2022 хотын стандарт шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй байх;

4.1.5. MNS6423:2019 стандартын шаардлага хангасан төле хяналтын систем суурилуулсан байх;

4.1.6. Малын эмч, малчин, харуул хамгаалалтын ажилтан зэрэг шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлсэн байх;

4.1.7. Ажил гүйцэтгэхэд шаардагдах тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх;

4.1.8. Харуул хамгаалалтын байртай байх;

4.1.9. Орчныхоо цэвэрлэгээг бүрэн хариуцаж, хог хаягдлыг түр хадгалах зориулалтын хогийн савтай, хог хаягдлыг нэгдсэн цэгт хаядаг байх;

4.1.10. Галын аюулгүй байдлыг хангасан байх;

4.1.11. Мал түр хадгалах хашаа, хороо, тоног хэрэгсэлд ариутгал халдвартгүйтгэл хийх тоног төхөөрөмжтэй байх;

Тав. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх баримт бичиг

5.1. Сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах баримт бичгийг хүлээн авна:

5.1.1. Албан хүсэлт;

5.1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

- 5.1.3. Өөрийн эзэмшил газартай бол газрын гэрчилгээ, кадастрын зураглал;
- 5.1.4. Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл, тайлан;
- 5.1.5. Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн, хуулийн этгээдийн харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт;
- 5.1.6. Өөрийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын танилцуулга, судалгаа, зураг төсөв;
- 5.1.7. Эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хэрхэн сайжруулах тухай төсөл, төсвийн тооцоолол;
- 5.1.8. Малын эмчийн мэргэжлийн диплом, итгэмжлэл
- 5.1.9. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй байгуулсан гэрээ;
- 5.2. Дээрх материал болон үнийн санал, хаяг, холбогдох утсаа тодорхой бичиж Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст ирүүлсэн байна;

Зургаа. Сонгон шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах

- 6.1. Сонгон шалгаруулалтад шалгарсан хуулийн этгээдтэй дүүргийн Ерөнхий менежер гэрээ байгуулна.
- 6.2. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
- 6.2.1. малыг түр хадгалах хашааны байршил, зохион байгуулалт;
- 6.2.2. хашаанд тавигдах шаардлага, хагалалт;
- 6.2.3. төлбөрийн хэмжээ, харуул хамгаалалт;
- 6.2.4. малыг хүлээн авах, өмчлөх, эзэмшигчид хүлээлгэн өгөх ажиллагаа;
- 6.2.5. гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, хариуцлага хүлээх;
- 6.2.6. бусад зардал;
- 6.3. Мал түр хадгалах хашааг ажиллуулж байгаа хуулийн этгээд нь "Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам"-ыг баримтлаагүй бол гэрээг цуцлах үндэслэл болно.

Долоо. Бусад зүйл

- 7.1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд аливаа байгууллага, албан тушаалтан, эрх бүхий этгээдийн зүгээс нөлөө үзүүлэхийг хориглоно.
- 7.2. Сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.